

04 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Төрийн үйлчилгээний чиглэлээр:

Сумын 100 жилийн ойд зориулсан улс аймгийн цолтой 256 бөхийн барилдааныг УБ хотод 4 сарын 22 нд сумын нутгийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. Энэ арга хэмжээн дээр Сумын уугуул Батлан хамгаалах яамны сайд агсан Ж.Ёндонгийн 100 насны ойд зориулсан хүндэт харуулын цэргийн үзүүлбэр тоглолт үзүүлсэн. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөхийн барилдаанд сумын Засаг даргын нөөцөөс 5,0 сая төгрөгийг зарцуулсан. Мөн Батлан хамгаалах яамнаас Ж.Ёндон генаралын 100 насны ойтой холбогдуулан зохион байгуулсан 3 эрдэм шинжилгээний бага хуралд Улаанбаатар хотын нутгийн зөвлөл болон ЗДТГ-ын төлөөлөл оролцсон.

Улсын бүртгэлийн үйлчилгээ: Төрсний бүртгэл 12, нас барсны бүртгэл 1, иргэний үнэмлэх олголтын бүртгэл 15, иргэний үнэмлэх хүчингүй болсны бүртгэл 14, шилжилт хөдөлгөөний бүртгэл 3, иргэний улсын бүртгэлийн лавлагаа 12 иргэнд олгож ажилласан. 4 сард нийт 75 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл газар болон түүнтэй холбоотой бүртгэл 4, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл 7 хийгдсэн. Тоон гарын үсэг 8 иргэнд олгосон.

Хууль эрх зүйн чиглэлээр:

Сумын ИТХ, ЗДТГ-аас зохион байгуулсан Бүх нийтэд "Эрүүл мэндийн боловсрол олгох" эрх зүйн сургалтыг Сүхбаатар аймгийн ЭМГ, НЭМТ, сумын ЭМТөв, Сүхбаатар аймаг дахь эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн, Цагдаагийн хэсэгтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Нийт 86 төрийн албан хаагчид, иргэд хамрагдсан.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Төсөвт байгууллагуудын 04 сарын гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч хянан баталгаажуулсан. Статистикийн хэлтэст сүм хийд, төрийн бус байгууллагын мэдээ, барилга байгууламжийн мэдээ, үнийн мэдээ, мал эмнэлгийн мэдээг 4 сард багтаан цаг хугацаанд нь илгээсэн. 04 сарын 10-30 ны хооронд Хүүхдийн цэцэрлэгийн гаднах тохижилт, гэр төсөл хэрэгжүүлэх, 04-ын ЦДАШ-ын шинэчлэлийн ажил, хүүхдийн тоглоомын талбай, ЛЕД дэлгэц зэрэг ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх ажлуудын тендер сонгон шалгаруулалтыг хийх үнэлгээний хороог байгуулж, сонин болон цахимд байршуулж тендерийг зарлаж сонгон шалгаруулалтыг хийж байна.

Нийтийн биеийн тамирын чиглэлээр : Суманд аймгийн аварга шалгаруулах өсвөрийн үндэсний бөхийн барилдаан , Өсвөрийн насны хүүхдийн волейболын тэмцээнийг аймгийн биеийн тамирын газартай хамтран зохион байгуулсан. Сумын ЗДҮАХХЗ-аас уг тэмцээнүүдийн зардалд 1900,0 мянган төгрөгийг зарцуулсан.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ИТХурлын 12 дугаар хуралдаанаар шинэчлэгдэн байгуулагдсан. Энэ сарын 24-нд зөвлөлийн хурлыг хуралдуулж сумын Малжуулах арга хэмжээнд хамрагдах 6 өрхийг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Зорилтот бүлгийн иргэд 10 Ахмад настангуудад Халамжийн өдрийн үйлчилгээнд 10 хоног хамруулсан. НДБайцаагчтай хамтран Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар мэдээлэл хийж, 7 ахмад настан суултуур, 1 ахмад настан тэргэнцэр 6 ахмад настан нурууны бүс захиалж суултуурыг гардуулан өгсөн.

ОНОТХҮ-ний төсөлд 2 иргэний 1 бүлгийн төсөл ирснийг АДЗөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж ХХҮГазарт хүргүүлсэн.

ХЭБҮ-нд энэ сард 6 өрхийн 29 иргэний 296.0 мянган төгрөгийн санхүүжилт

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт 114 /өссөн дүнгээр/ иргэн шалгуулснаас өөрийн биеэр 78, утсаар 36 иргэн үйлчлүүлсэн байна.

Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангаас олгогдох төслүүд зарлагдаж Мөнххаан сумын зар зарлалын нэгдсэн FB группэд мэдээллийг хүргэсэн. “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-т 6 иргэний төсөл, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөр”-т 2 иргэний төсөл, “Ахмад мэргэжилтнийг дэмжих хөтөлбөр”-т 2 иргэний төсөл, Зөвлөх үйлчилгээ төсөлд 1 төсөл ирсэн.

2023.04.25-нд Хөдөлмөрт бэлтгэх сургалтанд 6 иргэн цахимаар хамрагдсан.

2023.04.20-нд “Монголын удирдлага шинэчлэл, менежментийн академи” Сонор сургалтын төвтэй хамтран 9-12р ангийн 100 хүүхдэд АМЧБОлгох сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Эргэн төлөвлөлтийн хуваарийн дагуу 795,0 мянган төгрөг төвлөрүүлсэн.

Хугацаа хэтэрсэн эргэн төлөлт 650,0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд сумын ХАБЭА-н зөвлөлийн дарга цахим сургалтанд хамрагдсан. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа барилгын компани болон замын компани зэрэг тендерээр үйл ажиллагаа явуулж буй 5 ААНБайгууллагад ХАБЭА-н гарын авлага, аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хүргэж ажилласан.

ЕБС:Олон Улсын Логикпазллын олимпиадын 1-р шатны шалгаруулалт буюу аймгийн уралдаанд: Бага ангийн төрөлд 2 сурагч шагналт байр, дунд ангийн төрөлд 1 сурагч 3-р байр, ахлах ангийн төрөлд 1 сурагч 2-р байр улмаар 2-р шатны уралдаан буюу улсын уралдаанд оролцох Эрхийн бичгээр тус тус шагнагдлаа.

Сургуулийн удирдлага, багш нарын төлөөлөл 15 хүний баг бүрэлдэхүүнтэй Баруун-Урт сумын 3-р сургуулиас туршлага судлах чиглэлээр сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаатай танилцан судлагдахууны багш нар ажлын арга туршлагаасаа хуваалцлаа.

Сургуулийн эмч 6-р ангийн 86 сурагчдад гар утас цахим хэрэглээний талаар мөн

1-5 ангийн 510 сурагчдад гараа хэрхэн зөв угаах, 2-р ангийн 57 эцэг, эхчүүдэд хүүхдэд өглөөний цай уух нь хэр чухал вэ? сургалт, дотуур байрны 76 хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуй БЖИ талаар сургалт явуулсан.

Үндэсний сургалтанд 9 багш цахим, танхим хосолсон үндэсний сургалтанд хамрагдсан.

Соёл, урлагын үйлчилгээ:

Баруун бүсийн сумдын Урлагтай уулзалт нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж тус арга хэмжээнд аймгийн Соёл урлагийн газар, Түмэнцогт, Түвшинширээ, Уулбаян сумдын соёлын ажилтнууд оролцож харилцан туршлага судлах, хамтарсан арга хэмжээ, соёлын өвийн наадаан зэрэг арга хэмжээг зохион байгуулж тус арга хэмжээнд 30 соёлын ажилтнууд хамрагдлаа.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Энэ жилдээ -Эрүүл жиндээ” аяны хэрэгжилтийг хангах зорилгоор Бүжгээр эрүүлжье аяныг 10 хоногийн турш зохион байгуулж тус бүжгийн сургалтанд 68 албан хаагч 15 иргэд хамрагдаж нийт Цэнгээнт бүжгийн 16 элементийг сурсан байна.

Соёл урлагийн нэгдсэн 15 арга хэмжээ гадны тоглолт 5 , кино үзвэрийн үйлчилгээ 3, байгууллагаас зохион байгуулсан 7арга хэмжээнд нийт 1997 үйлчлүүлэгч хамрагдсан байна.

НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Номын сангийн явуулын үйлчилгээг 7 удаа танхимын үйлчилгээг 16 удаа хүргэн танхим болон явуулын үйлчилгээгээр 113 иргэнд 151 номоор үйлчиллээ.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Номтой өглөө хэлэлцүүлэг уулзалтыг 2 дахь удаагаа амжилттай зохион байгуулсан.

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Баруун бүсийн сумдын соёлын ажилтнуудын дунд Соёлын өвийг сурталчлах зорилгоор Дөрвөн бэрх тэмцээнийг зохион байгуулж тус арга хэмжээнд 24 соёлын ажилтнууд хамрагдлаа.

Музейн боловсролын хөтөлбөр

Үндэсний түүх соёлоо сурталчлан таниулах зорилгоор Соёлын төвд Чингис хааны эш хөрөг залах арга хэмжээг зохион байгуулж Чингис хааны үйл хэргийг сурталчлах зорилгоор танилцуулга арга хэмжээг зохион байгуулж тус арга хэмжээнд дугуйлангийн 34 сурагчид оролцлоо.

Ахмад настан, хүүхэд залуучуудад зориулсан Музейн боловсрол олгох хөтөлбөрт арга хэмжээг сумын Хүүхдийн элчтэй хамтран зохион байгуулж үйл ажиллагаандаа дотуур байрны 79 сурагчдыг 100 хувь хамруулан сумын 5 багаас 56 ахмад настнууд 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулж ажиллаа.

Хүүхэд хөгжил хамгааллыг дэмжих жилийг тохиолдуулан Дарьгангын аман билгийг сурталчлах хүүхэд залуусд өвлүүлэх, танин мэдэхүй, ёс зүй, хүмүүжил, соёлын боловсрол олгох үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулах зорилготой Үлгэрч Сүхбаатарчууд соёлын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Хөгжим бүжгийн багшийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 1-р улирлын дугуйлан сургалтын үйл ажиллагааны үр дүнг тайлагнах өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Тус арга хэмжээнд 4 төрлийн дугуйланд суралцдаг 67 сурагчид 17 эцэг эх хамрагдан тайлант өдөрлөгийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд урлаг уран бүтээлийн зардлаас 450,000 төгрөгийг зарцуулан ажилласан байна. Энэ жилдээ-Эрүүл жиндээ аяны хүрээнд сургуулийн насны 13-17 насны сурагчдад Нийтийн цэнгээнт бүжгийг зааж сургах ажлыг эхлүүлэн 4 сард 5 удаагийн сургалтанд нийт 97 сурагчид хамрагдан суралцаж байна.

Урлаг уран бүтээлийн чиглэлээр

Бага насны хүүхдэд театр урлагийн боловсрол олгох ажлын хүрээнд МУ-ын Хүүхэлдэйн театрын уран бүтээлчдийн А.Н. Толстойн зохиол Алтан залаат азарган тахиа хүүхэлдэйн жүжгийг сумын хүүхэд багачуудад толилуулан нийт 300 гаруй сурагчид, 14 эцэг эх багш сурган хүмүүжүүлэгчид үзэж сонирхлоо.

Сумын ард иргэдэд Театр урлагийн боловсрол олгох ажлын хүрээнд Жаахан шарга театрын уран бүтээлчдийн А.Вампиловын зохиол У.Эрдэнэбаярын найруулга “100 тоот өрөө” инээдмийн жүжгийг толилуулан 120 гаруй иргэд үзэж сонирхлоо.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2023 оны 04 сарын 28-ны байдлаар 45 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 33 насанд хүрэгчид, 12хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. Амбулаторийн үзлэг 385, урьдчилан сэргийлэх үзлэг 125 байна. 6-8 ангийн нийт 283 сурагчаас 274/96,8%/сурагчдын дунд сүрьеэгийн халдвар илрүүлэх талаар үзлэг хийж, асуумж авч шаардлагатай хүүхдэд туберкулины сорил 80 хүүхдэд тавихаар захиалсан. Эрсдэл өндөртэй 7в ангийн 32 хүүхэд болон ханиалгасан зовиуртай нийт 80 хүүхдийг хамруулахаар болсон

9-12 ангийн 220 хүүхдээс 203/92,2%/ сурагчдад рентген зураг авч, эмчийн үзлэг хийж, асуумж судалгааг авсан. Үүнээс шаардлагатай хүүхдүүдийн нэрсийг түүж цэрний шинжилгээнд хамруулах талаар сургуулийн эмчид мэдээлэл өгсөн.

“Эрүүл Сүхбаатар” төслийн хүрээнд 3185 хүнээс ЭМДаатгалд хамрагдаж байгаагүй иргэдийн судалгааг HEALT программ дээрээс нэг бүрчлэн түүж даатгалгүй иргэдийн судалгааг гаргаж ЭМГазарт хүргүүлсэн.

“Эрүүл Сүхбаатар” “С Гепатитгүй Сүхбаатар” төслийн хүрээнд Мөнххаан сумын 19-өөс дээш насны хүн амын дунд ЭМДаатгалд хамрагдаагүй болон В, С виурстэй хүмүүсийн судалгааг нарийвчлан гаргаж иргэдийг В,С вирусын шинжилгээнд хамруулж байна.

Түргэн тусламжийн дуудлага 93 ирснээс алсын дуудлага–18, ойрын дуудлага75 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Гурав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 16 дугаартай шинжилгээнд хонины цэцэг өвчин оношлуулахаар аймгийн мал эмнэлгийн лабораторид хүргүүлсэн. Шинжилгээний дүнг гартал сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/53 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмийг тогтоосон. УМЭАЦТЛ-ийн 2023 оны 04 дугаар сарын 19-ны өдрийн 23-3143 тоот шинжилгээний дүнгээр хонины цэцэг өвчин болох нь батлагдсан тул мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн 2023.04.20-ны өдрийн 01 тоот дүгнэлтийг үндэслэн сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 59 тоот захирамжаар хорио цээрийн дэглэмийг тогтоож, ажлын хэсгийг томилон тухайн өвчинтэй тэмцэх зааврын дагуу арга хэмжээг авч байна.

Үзлэгээр өвчний шинж тэмдэгтэй хурга нь 40,8С⁰ халуунтай, биеийн арьсны нимгэн хэсэгт гүвдрүү гарсан байв.Тухайн хургыгзориудын устгалд хамруулж стандарт арга зүйн дагуу лабораторийн шинжилгээнд гүвдрүү, элэг, бөөр, дэлүү, уушиг, зүрхний дээж авч УМЭАЦТЛ-т баталгаажуулах шинжилгээнд өгснөөр УМЭАЦТЛ-ийн 2023.04.19 өдрийн 23-3143 тоот шинжилгээний дүнгээр хонины цэцэг өвчин болох нь баталгаажсан.

Голомтод 2 өрхийн 249 хурга өвчлөснөөс 12 хурга үхэж,1 хургыг зориудын устгалд оруулж.Голомтын болон сэжигтэй бүсэд Мөнххаан сумын 24 өрх, Уулбаян сумын 11 өрхийн 3286 толгой хонь, 5836 хурга, нийт 9125 хонь байна.Уулбаян сумын хонинд хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулалт 2022 онд хийгдээгүй тул голомтын бүсийн 3286 хонь, 5836 хургыг вакцинжуулалахад 9122 тун вакцин шаардлагатай. Тухайн голомт болон сэжигтэй бүсийн хонинд эрүүл мэндийн үзлэг, тандалтыг хийж эхлүүлээд байна. Зориудын устгалд хамруулсан малыг устгаж халдваргүйтгэл арга хэмжээг хийж байна.Үүнд: хашаа,хороо, тоног хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, устгалын цэг, худаг уст цэгийн 6000 м2 талбайд халдваргүйтгэл хийгдээд байна.

Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалт 43.0 сая төгрөгийн санхүүжилтээр сумын нутаг дэвсгэрт оготно устгал хийх ажилд 8 тн оготнын хорийг нийлүүлж устгалын ажлыг иргэд малчид төрийн албан хаагчдын оролцоотойгоор 4/17-4/20 ны өдрүүдэд зохион байгуулсан.

Гурав: Газрын харилцаа, байгаль орчны чиглэлээр:

Газрын дуудлага худалдааны орлого 39940,0 төгрөгийн орлого төрийн санд төвлөрсөн. Мөн газар чөлөөлөтийн ажлын хэсэг байгуулан 8 өрхийн 1 байшин, 7

хашааг буулгаж, нийт 9,5 сая төгрөгийн нөхөн олговрын гэрээ хийлээ. Түүнчлэн тус ажлыг хийж гүйцэтгэхэд 1,3 сая төгрөгийн зардал гарсан болно. ЗГ-ын тогтоол гарсантай холбогдуулан газар өмчлөлийн 3 иргэний өргөдөл, эзэмшлийн 8 иргэний өргөдлийг авч ажиллаад байна.

Мөнххаан сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/37 тоот захирамж болон тамгын газрын даргын “Сэг зэмийн устгал ариутгалын удирдамж” гарган батлуулан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч, сумын төв орчим, улсын чанартай төв зам дагуу мөн 3-р багийн нутаг дэвсгэрт байрлах Цээл нуурын орчмын бүс нутагт хаягдсан эзэнгүй хог хаягдал, малын сэг зэмийн цэвэрлэгээг хийж, булж устгах, халдваргүйжилт хийж ажилласан.

Сэг зэм устгах, халдваргүйтгэл хийх ажилд шатах тослох материал 730,0 төгрөгийн зардал гарсан. Бог мал 295, Бод 135 нийт 430 малын сэг зэмийн цуглуулан, цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн. Нийтийн эзэмшлийн 85,1 м² талбайд халдваргүйтгэлийг хийсэн.

Сумын төвд байгаа тэнэмэл, золбин нохойг устгах ажлыг 2023 ны 03 дугаар сарын 31-нд Хэнтий аймгийн төвөөс нохой устгадаг иргэнтэй гэрээ байгуулан устгуулсан. Сумын хэмжээнд нийт 71 нохойг устгаж, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ арга хэмжээнд 1824,0 мянган төгрөгийн шатах, тослох материалын зардал гарсан. Тус сумын 5-н багийн иргэдийн нийтийн хурлуудад 152-н иргэнд галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх, галын аюулгүй ажиллагааны талаар зааварчилгааг таниулах, олон нийтэд сурталчилах ажлыг хийсэн. Мөн сумын веб сайт пэйж FB хуудас 12 удаа мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэж нийт 112 хүний хандалтыг авч сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.

